ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 10 сарын 29 өдөр Дугаар 144 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлөө хүчингүй болгох талаар гаргасан хүсэлтийнх нь дагуу “Завхантоль сонин” ХМХ-ийн Завхан аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000041 тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг өөрт нь болон зөвшөөрөл эзэмшигчийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР